

БАТЛАВ  
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГА  
Ө. СУМЬЯАБААТАР

2025 оны 05 дугаар сарын

БАТЛАВ  
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН БИЕЙН  
ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГА Г. БАТБАЯР

2025 оны 05 дугаар сарын 12

УДИРДАМЖ

2025 оны 05 дугаар сарын 09

Улаанбаатар хот

## БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМ

Нэг. Үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газраас бүсчилсэн хөгжил реформыг эхлүүлж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдүгээр бүлэг "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Баянгол дүүргийн түүхт 60 жилийн ойн хүрээнд, "Биеийн тамир, спортын тухай хууль"-ийн 11.1.3 дугаар зүйл, Баянгол дүүргийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.5.3 дах заалтыг тус тус үндэслэн.

1.2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр бүсийн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулахыг, мөн оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлээр "Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллах"-ыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон.

1.3. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын хөгжлийг бүсийн онцлог байдалтай уялдуулах, бүсийн хөгжлийг дэмжих хүрээнд олон талт арга хэмжээг зохион байгуулах, нэгдсэн удирдамжаар хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Зорилго

2.1. Дүүргийн хэсэг, хороо, бүс, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэдний идэвх сонирхолыг дэмжих, иргэдийг спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, биеийн дархлааг дэмжихэд тэмцээний зорилго оршино.

Гурав. Наадмын зохион байгуулалт, удирдлага

3.1. Наадмын үйл ажиллагааг бүх талаар удирдан зохион байгуулах үүргийг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо гүйцэтгэнэ.

3.2. Наадмыг Биеийн тамир, спортын хорооны нэгдсэн удирдамжийн дагуу зохион байгуулна.

3.3. Тэмцээнийг хороод, дүүрэг, нийслэл, улс гэсэн 5 үе шатай зохион байгуулна.

Дөрөв. Наадмын явагдах хугацаа, үе шат, оролцогчид, спортын төрөл

4.1. Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 11-ны өдрийн хооронд зохион байгуулна.

| № | Спортын төрөл   | Насны ангилал                           | Хүйс    | Баг тамирчдын тоо | Хугацаа, заал талбай                                 |
|---|-----------------|-----------------------------------------|---------|-------------------|------------------------------------------------------|
| 3 | Волейбол        | Залуучууд (19-30 нас)                   | Эрэгтэй | 9 тамирчин        | 2025.05.24-25<br>БТСХ, 113-р сургууль                |
|   |                 |                                         | Эмэгтэй | 9 тамирчин        |                                                      |
|   |                 | Идэрчүүд (31-44 нас)                    | Эрэгтэй | 9 тамирчин        | 2025.05.24-25<br>77-р сургууль, 13-р                 |
|   |                 |                                         | Эмэгтэй | 9 тамирчин        |                                                      |
|   |                 | Ахмад (45-аас дээш)                     | Эрэгтэй | 9 тамирчин        | 2025.06.11-12<br>113-р сургууль                      |
|   |                 |                                         | Эмэгтэй | 9 тамирчин        |                                                      |
| 2 | Сагсан бөмбөг   | Залуучууд (19-30 нас)                   | Эрэгтэй | 8 тамирчин        | 2025.06.07-08<br>БТСХ, 28-р сургууль<br>шинэ заал    |
|   |                 |                                         | Эмэгтэй | 8 тамирчин        |                                                      |
|   |                 | Идэрчүүд (31-44 нас)                    | Эрэгтэй | 8 тамирчин        | 2025.06.07-08<br>Сэтгэмж цогцолбор,<br>22-р сургууль |
|   |                 |                                         | Эмэгтэй | 8 тамирчин        |                                                      |
|   |                 | Ахмад (45-аас дээш)                     | Эрэгтэй | 8 тамирчин        | 2025.06.11-12<br>БТСХ                                |
|   |                 |                                         | Эмэгтэй | 8 тамирчин        |                                                      |
| 3 | Ширээний теннис | Залуучууд (19-30 нас)                   | Эрэгтэй | 1 тамирчин        | 2025.05.24<br>Билэгт ширээний<br>теннисний клуб      |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 | Идэрчүүд (31-44 нас)                    | Эрэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 | Ахмад (45-аас дээш)                     | Эрэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |
| 4 | Шатар           | Насанд хүрэгчид (18 наснаас дээш)       | Эрэгтэй | 1 тамирчин        | 2025.05.25<br>БТСХ                                   |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |
| 5 | Үндэсний бөх    | Насанд хүрэгчид (18 наснаас дээш)       | Баг     | 4 тамирчин        | 2025.06.10<br>БТСХ                                   |
| 6 | Шагай           | Залуучууд (18-55 нас)                   | Эрэгтэй | 9 тамирчин        | 2025.06.10<br>БТСХ                                   |
|   |                 | Идэрчүүд (56-аас дээш)                  | Эрэгтэй | 9 тамирчин        |                                                      |
| 7 | Үндэсний сур    | Залуучууд (18-25 нас) (их сурын харваа) | Эрэгтэй | 1 тамирчин        | 2025.06.09-10<br>Үндэсний сурын талбай               |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 | Идэрчүүд (26-аас дээш, их сурын харваа) | Эрэгтэй | 1 тамирчин        |                                                      |
|   |                 |                                         | Эмэгтэй | 1 тамирчин        |                                                      |

Тав. Наадамд оролцогчдод тавигдах шаардлага

5.1. Спортын их наадамд оролцох тамирчид нь тухайн спортын төрлийн спортын дэд мастер болон түүнээс дээш, үндэсний спортын төрлүүдийн цолтой тамирчид тус тус оролцохыг хориглоно.

5.2. Дүүргийн спортын их наадамд хороодыг төлөөлж оролцоно. Улсын Бүсчилсэн хөгжлийн спортын их наадамд оролцох баг тамирчдыг дүүргийн Биеийн тамир, спортын хорооны санал болгосноор дүүргийн Засаг дарга баталж оролцуулна.

5.3. Багийн бүрэлдэхүүн тухайн хорооны оршин суугч байх ба түүнийг цахим иргэний үнэмлэх, E-Mongolia системээс авсан оршин суугаа хаягын тодорхойлолт, иргэний үнэмлэхний лавлагааг үндэслэн наадамд оролцуулна.

5.4. Цол зэрэгтэй тамирчдыг [sport.gov.mn/dergees](http://sport.gov.mn/dergees) сайт болон бусад холбогдох нөхцөлөөр шалгана.

5.5. Наадамд оролцох тамирчид төрөл давхцахгүй зөвхөн нэг төрөлд оролцоно.

5.6. Баг тамирчид тухайн спортын төрөлд жигд хувцастай оролцоно.

5.7. Нээлт болон хаалтад оролцохдоо туг болон 20см х 40см хэмжээтэй хаяг, тугтай байна.

5.8. Тэмцээнд оролцогч тамирчдын зардал, эрүүл мэнд болон бусад холбогдох асуудлыг тухайн хороо бүрэн хариуцна.

5.9. Дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос гаргасан нэгдсэн зааврыг зөрчсөн тохиолдолд тэмцээн тус бүрээс шууд хасна.

5.10. Зөрчил гаргасан хороонд торгууль 40 оноог өгнө

5.11. Спортын төрөл тус бүрийн зохион байгуулалт, нэмэлт шаардлагатай дүрэм, журам өөрчлөлтийг тухайн тэмцээний техникийн зөвөлгөөн дээр хэлэлцэн шийдвэрлэнэ.

Зургаа. Дүгнэх журам, шагнал

7.1. Спортын төрөл тус бүрийн эхний 3 байрыг шалгаруулж алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Холбогдох утас: 70141983, 86072636, 91990368, 99948632, 90699339

БОЛОВСРУУЛСАН:

БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Х. ОЮУНДЭЛГЭР